



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023
ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

**ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮНГИЙН ТАЛААР
ИРГЭДЭД ХҮРЭХ МЭДЭЭЛЭЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

АУДИТЫН КОД: ОРА-2024/26-12-ШТА-ГА

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Оргилмөрөн
Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn
Аудитор: О.Гантуяа
Утас: 70355805 Цахим хаяг: gantuyao@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар A/06

Эрдэнэт

“Аудитын тайлан баталгаажуулах тухай”

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.1, 1.4 дэх хэсэг, “Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-д хийсэн аудитын тайлан /ОРА-2024/26-12-ШТА-ГА/-г баталгаажуулсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, аймгийн хэмжээнд нэгтгэн, үр дүнгийн талаар 2025 оны 06 сарын 20-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга (М.Түмэнжаргал), Баян-өндөр сумын Засаг дарга (Б.Баасансүрэн), Жаргалант сумын Засаг дарга (Б.Зоригтбаяр) нарт зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Баян-өндөр сумын Засаг дарга, Жаргалант сумын Засаг дарга нарт хүргүүлж, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Б.Буян-Ундрах), ахлах аудитор (Г.Оргилмөрөн) аудитор (О.Гантуяа) нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ



Аудитыг гүйцэтгэсэн:	АГУУЛГА	
	Товчилсон үгийн жагсаалт.	5
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл.	6
	Үндсэн мэдээлэл.	8
Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор:	БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУУЛЬ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ХУВААРИЛСАН, АЙМГИЙН ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАХ-Г ТӨЛӨВЛӨХДӨӨ СУМДЫН САНАЛЫН ЖАГСААЛТЫГ АВЧ ЭРЭМБЭЛЭЭГҮЙ БАЙНА.	9
Ц.Нармандах		
Аудитын менежер: Б.Буян-Ундрах	1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 188.1 сая төгрөгөөр дутуу олгожээ.	9
Ахлах аудитор: Г.Оргилмөрөн	1.1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийн талаар орон нутгийн түвшинд тодорхой мэдээлэл байхгүй байна.	9
Аудитор: О.Гантуяа	1.1.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг улсын төсөвт төвлөрдөг газрын тосны орлого тасарсантай холбоотойгоор дутуу олгосон байна.	9
2024 оны 07 дугаар сар	1.1.3 Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас Баян-Өндөр сумын орон нутгийн хөгжлийн санд 23.0 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон байна.	10
Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах, холбогдох саналаа өгөхийг хүсвэл 70357955, 70350757 дугаарын утас, 70359826 дугаарын факсаар харилцана уу.	1.1.4 Аймгийн ОНХС-д “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн хамтын ажиллагааны хүрээнд 2,800.0 сая төгрөг, сумдын ОНХС-д малын тоо толгойн албан татварын 60.3 сая төгрөгийг тус тус нэмж төлөвлөсөн байна	11
Аудитын тайланг ҮАГ-ын www.open.audit.mn цахим хуудаснаас үзнэ үү.	1.2 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө сумдын саналын жагсаалтыг авч эрэмбэлээгүй байна.	12
	1.2.1 ОНХС-н төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа хангалтгүй, иргэдийн санал аваагүй зарим ТАХ-г төлөвлөж, ИТХ-аар баталсан байна	12
	1.2.2 Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим ТАХ-г төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулаагүй байна.	15
	1.2.3 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд 283 ТАХ-г 20,680.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсны 13,591.1 сая төгрөгийн 157 ТАХ нь шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ байна.	16
	1.2.4 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хууль, журмаар тогтоосон чиг үүрэгт хамаарах ТАХ-г хэрэгжүүлэхээр тусгасан байна.	17
Хаяг: Орхон аймаг дахь Төрийн аудитын газар	БҮЛЭГ 2. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ ХАНГАЛТГҮЙ, ЦАГ ХУГАЦААНДАА ХЭРЭГЖҮҮЛЖ ДУУСГАХАД АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	18
Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, Нутгийн удирдлагын ордон	2.1 ОНХС-ийн хөрөнгөөр ТАХ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийн зарим заалтыг зөрчсөн байна.	18
	2.1.1 Сангийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн зарим заалтуудыг зөрчин зохион байгуулсан байна	18
	2.1.2 Жаргалант сумын ОНХС-д болзошгүй аваарын зардал 209.0 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 204.8 сая төгрөг зарцуулсан байна.	20

2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг аймгийн хэмжээнд нэгтгэн судалж, тооцоогүй байна.	21
2.2.1 Өмнөх онуудад төлөвлөсөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй зарим ТАХ-г хугацаанд нь ашиглалтад оруулаагүйгээс бодит үр дүн гарахгүй байна	21
2.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн томоохон төсөл арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахаар байна.	22
2.3 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон зарим ТАХ нь хугацаандаа бүрэн ашиглалтад ороогүй, гэр хороололд тавигдсан шугам сүлжээнд холбогдох айл, өрхийн идэвх, оролцооноос хамаарч хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.	23
2.3.1 Төлөвлөсөн ажлуудыг цаг хугацаанд нь бүрэн ашиглалтад оруулахад хяналт, шахалт тавьж ажиллах шаардлагатай байна.	23
2.3.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон нийтийн эзэмшлийн зарим ТАХ-ний хадгалалт, хамгаалалтад хангалтгүй байна.	24
БҮЛЭГ 3. ОНХС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВЬЖ БУЙ ХЯНАЛТЫН ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙГЭЭС ЗӨРЧИЛ ДУТАГДАЛ АРИЛАХГҮЙ БАЙНА.	26
3.1 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ТАХ-нд тодорхой түвшинд хяналт хэрэгжүүлж буй боловч гүйцэтгэлийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна.	26
3.1.1 Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад аймгийн СХДАА, сумын ИТХ-аас хяналт хэрэгжүүлсэн байна.	26
3.1.2 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад Хот байгуулалт барилга захиалагчийн алба болон тухайн аймаг, сумын ЗДТГ-аас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж буй ч төлөвлөсөн хугацаанд бүх ажлын гүйцэтгэлийг бүрэн хангаж чадахгүй байна.	26
3.1.3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.	27
3.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам, зааврын дагуу тайлагнаагүй байна.	27
3.2.1 Аймгийн ЗДТГ-ын ХБТХО-ын хэлтэс чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.	27
3.2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.	28
3.2.3 Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг удирдлагын мэдээллийн системд хэрэгжиж дуусаагүй ТАХ-г дутуу оруулсан байна.	28
3.2.4 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цаг тухай бүрд нь мэдээлсэн байна.	29
ДҮГНЭЛТ.....	30
ЗӨВЛӨМЖ.....	31
Холбогдох байгууллагын санал.....	32

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуй нэгж
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АМАТЗ	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТХЗ	Захиалагчийн техник хяналтын зардал
ЗТЗ	Зураг төсвийн зардал
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МТ	Магнай трейд
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨХБАҮХТТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТХ	Төсвийн тухай хууль
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХБ	Худалдаа хөгжлийн банк
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ШДНЦХ	Шилэн дансны нэгдсэн цахим хуудас

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1	Аймаг, сумын ОНХС-д олгосон төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл.	8
Хүснэгт 2	Орлогын эх үүсвэрийн төлөвлөгөөг харуулбал.	9
Хүснэгт 3	ОНХНС-аас олгосон санхүүжилтийн хуваарь.	10
Хүснэгт 4	Сумдын ОНХС-д орлогын шилжүүлэг.	10
Хүснэгт 5	Сумдын ОНХС-д олгосон санхүүжилт.	11
Хүснэгт 6	Аймаг, сумын ОНХС-ийн өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл.	11
Хүснэгт 7	Орхон аймгийн 20-оос дээш насны хүн амын тоо, ОНХС-д санал өгсөн иргэдийн тоо.	14
Хүснэгт 8	Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ.	16
Хүснэгт 9	Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга.	17
Хүснэгт 10	Болзошгүй аваарын зардалд баталсан төсвийн зарцуулалт.	20
Хүснэгт 11	Орхон аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт.	23
Хүснэгт 12	Аймаг сумын ОНХС-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шийдвэр, түүний хэрэгжилт.	27

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162, “Аудитын сэдэв батлах тухай” А/100 дугаар тушаал, “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/152 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

ОНХС-ийн 2024 оны хөрөнгийн зарцуулалтад хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймаг, сумын ИТХ, Засаг дарга, ЗДТГ, холбогдох хэлтэс, албад, байгууллага, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”
- Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудит хийж гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах хянан удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Г.Оргилмөрөн, аудитор О.Гантуяа нар гүйцэтгэв.

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа:

Аудитын талбарын ажлыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 06 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн, тайланг 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн дотор үе шатны хяналтаар оруулж, баталгаажуулан, 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүллээ.

Үндсэн мэдээлэл:

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-т “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс Орхон аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 16,970.4 сая төгрөгөөр баталсан байна.

Төлөвлөгөөний гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт 1. Аймаг, сумын ОНХС-д олгосон төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөг)

№	Аймаг, сум	ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг		Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 50%		"Тогтвортой амжиргаа-3" төсөл		Нийт	
						Урамшуулал			
		Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
1	Аймгийн төв	7,790.0	7,591.9	53.7	40.6	0.0	0.0	7,843.7	7,632.5
2	Баян- Өндөр	3,702.5	3,725.5	15.8	15.8	549.5	549.5	4,267.8	4,290.8
3	Жаргалант	4,087.5	4,087.5	37.9	37.9	733.5	733.5	4,858.9	4,858.9
Нийт дүн		15,580.0	15,404.9	107.4	94.3	1,283.0	1,283.0	16,970.4	16,782.3

ОНХС-ийн мэдээллийг иргэдэд үнэн зөв, түргэн шуурхай хүргэх зорилгоор “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс санхүүжүүлэн “Удирдлагын мэдээллийн систем”-ийг Сангийн яамны сайтад байршуулсан байна. Энэхүү системд ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг оруулахаар холбогдох журамд заажээ.

Үүний дагуу аймаг, сумын 2023 оны ОНХС-ийн мэдээллийг уг системд оруулсан байдлыг 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөр хянахад мэдээлэл оруулалт хангалтгүй байна.

ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдэл аймгийн хэмжээнд 932.6 сая төгрөг, тайлант онд нийт 19,427.8 сая төгрөгийг төвлөрүүлж, 15,408.3 сая төгрөгийг зарцуулснаар эцсийн үлдэгдэл 4,952.1 сая төгрөг болсон байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд аймгийн хэмжээнд нийт 286 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр 29,940.4 сая төгрөгийг баталснаас бүрэн хэрэгжсэн 200 төсөл, арга хэмжээнд 11,693.1 сая төгрөг, дутуу хэрэгжсэн, он дамжин хэрэгжих 8 төсөл, арга хэмжээнд 3,715.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Бүлэг 1

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу хуваарилсан, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г төлөвлөхдөө сумдын саналын жагсаалтыг авч эрэмбэлээгүй байна.

1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 188.1 сая төгрөгөөр дутуу олгожээ.

1.1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийн талаар орон нутгийн түвшинд тодорхой мэдээлэл байхгүй байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэхээр заасан байна.

- Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь
- Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал
- Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь

1.1.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг улсын төсөвт төвлөрдөг газрын тосны орлого тасарсантай холбоотойгоор дутуу олгосон байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс Орхон аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 16,970.4 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 2. Орлогын эх үүсвэрийн төлөвлөгөөг харуулбал:

/сая.төгрөг/

Аймаг	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	Газрын тосны нөөц ашигласны төлбөр	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл	Олон Улсын төсөл хөтөлбөрөөс сумдын ОНХС-д олгох урамшуулал	Нийт
Орхон	15,203.3	376.7	107.4	1,283.0	16,970.4

Үүнд: ОНХНС-ийн орлогын шилжүүлэг¹ 15,580.0 сая, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр² 107.4 сая, “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс³ 1,283.0 сая төгрөгийг тус тус бүрдүүлэхээр төлөвлөжээ.

¹ Төсвийн тухай хуулийн 60.2.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг

² Төсвийн тухай хуулийн 60.2.7. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь.

³ Төсвийн тухай хуулийн 59.1.3. Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;

Гүйцэтгэлээр аймгийн орон нутгийн хөгжлийн санд нийт 16,782.3 сая төгрөг олгож 188.1 сая төгрөгийг дутуу хуваарилсан байна.

Хүснэгт 3. ОНХНС-аас олгосон санхүүжилтийн хуваарь.

/сая.төгрөг/

Улирал	Санхүүжилт			Үүнээс: Төслийн урамшуулал		
	Хуваарь	Гүйцэтгэл	Зөрүү	Хуваарь	Гүйцэтгэл	Зөрүү
I	2,128.3	2,115.5	12.8			
II	4,967.3	4,824.1	143.2	1,283.0	1,283.0	0.0
III	4,937.4	4,972.8	-35.4			
IV	4,937.4	4,869.9	67.5			
Дүн	16,970.4	16,782.3	188.1	1,283.0	1,283.0	0.0

Дээрхээс харахад 2, 4 дүгээр улиралд ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу олгоогүй, тасарсан, харин Олон Улсын төсөл хөтөлбөрөөс сумдын ОНХС-д олгох урамшуулал хугацаандаа, хуваарийн дагуу бүрэн олгогдсон байна.

1.1.3 Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас Баян-Өндөр сумын орон нутгийн хөгжлийн санд 23.0 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолын⁴ хавсралтаар баталсан аргачлалд тодорхойлсон итгэлцүүрийн дагуу ОНХС-д нийт 9,126.7 сая төгрөг хуваарилагдахаар тооцоолсон байна.

Аймгийн ИТХ-ийн 2023 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн Ээлжит бус XII хуралдааны 12/02 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг нийт 9,126.7 сая төгрөгөөр баталсан байна.

Дээрх тогтоолд сумдад олгох орлогын шилжүүлгийг аргачлалын дагуу тооцоолсон нийт дүнгээр үнэн зөв тусгасан боловч тухайн сумын дүнгээр буюу Жаргалант сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 2.8 сая төгрөгөөр илүү, Баян-Өндөр сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 2.8 сая төгрөгөөр дутуу тусган баталсан байна.

Хүснэгт 4. Сумдын ОНХС-д орлогын шилжүүлэг.

/сая.төгрөг/

№	Сумын нэр	Алслагдсан хамраах 30%	Хүн амын тооноос хамраах 40%	Нутаг дэсвгэрээс хамраах 30%	Итгэлцүүр нийт дүн	Урамшуулал	АМАТЗ-ийн төлбөр	Сумын ОНХС-д хуваарилагдах дүн	АИТХ-аар баталсан дүн	Зөрүү
1	Баян-Өндөр	0.0	3,015.8	689.5	3,705.3	549.5	15.8	4,270.6	4,267.8	-2.8
2	Жаргалант	2,337.0	100.2	1,647.5	4,084.7	733.5	37.9	4,856.1	4,858.9	2.8
	Дүн	2,337.0	3,116.0	2,337.0	7,790.0	1,283.0	53.7	9,126.7	9,126.7	0.0

Жаргалант сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг бүрэн олгож, Баян-Өндөр сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Баян-Өндөр сумын ерөнхий

⁴ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал".

орлогын дансанд нээсэн урьд оны үлдэгдлээс олгох малын хөлийн татварыг аймгийн ОНХС-аас дахин санхүүжүүлж 23.0 сая төгрөгийг илүү олгосон байна.

Дээрх Баян-өндөр сумын ОНХС-д илүү олгосон 23.0 сая төгрөгийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад залруулж, 2024 оны 02 сарын 27-ны өдөр журнал ваучер бичиж аймгийн ОНХС-ийн дансанд буцаан татсан байна.

Энэ залруулгын дагуу Баян-Өндөр сумын ОНХС-ийн санхүүгийн тайланд мөн залруулга хийж, санхүүжилт болон мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг бууруулж тайлагнажээ.

Хүснэгт 5. Сумдын ОНХС-д олгосон санхүүжилт.

/сая төгрөг/

№	Аймаг, сум	ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг		АМАТЗ-н төлбөр 50%		"Тогтвортой амжиргаа-3" төсөл		Нийт	
		Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Урамшуулал		Төлөв	Гүйц
2	Баян-Өндөр	3,702.5	3,725.5	15.8	15.8	549.5	549.5	4,267.8	4,290.8
3	Жаргалант	4,087.5	4,087.5	37.9	37.9	733.5	733.5	4,858.9	4,858.9
Нийт дүн		7,790.0	7,813.0	53.7	53.7	1,283.0	1,283.0	9,126.7	9,149.7

Баян-Өндөр сумын ОНХС-д 23.0 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосонтой холбоотойгоор аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг нийт дүнгээр 211.2 сая төгрөгөөр тасарсан байна.

Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцоолсон дүнгээр сумдад төлөвлөж батлах, баталсан санхүүжилтийг тухай бүр хуваарийн дагуу олгож, хяналт тавих шаардлагатай байна.

1.1.4 Аймгийн ОНХС-д “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн хамтын ажиллагааны хүрээнд 2,800.0 сая төгрөг, сумдын ОНХС-д малын тоо толгойн албан татварын 60.3 сая төгрөгийг тус тус нэмж төлөвлөсөн байна.

Аймаг сумын ОНХС-ийн өөрийн орлогын эх үүсвэрийг дараах байдлаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 6. Аймаг, сумын ОНХС-ийн өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл. /сая.төг/

№	Сумын нэр	Эхний үлдэгдэл		ТТХ-ийн 60.2.5 ⁵		Бусад орлого		ТТХ-ийн 60.2.8 ⁶		Нийт эх үүсвэр	
		Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
1	Аймгийн төв	646.8	704.4	2,800.0	2,600.0	7.0	7.0	0.0	0.0	3,453.8	3,311.4
2	Баян-Өндөр	123.1	155.4	0.0	0.0	0.0	1.2	23.0	0.0	146.1	156.6
3	Жаргалант	72.8	72.8	0.0	0.0	0.0	0.0	37.4	37.4	110.1	110.1
Нийт дүн		842.7	932.6	2,800.0	2,600.0	7.0	8.2	60.4	37.4	3,710.1	3,578.1

⁵ Төсвийн тухай хуулийн 60.2.5. “тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг”

⁶ Төсвийн тухай хуулийн 60.2.8. “малын тоо толгойн албан татварын орлого. ...”

Дээрх хүснэгтээс харахад аймаг, сумын ОНХС-д эхний үлдэгдлээр 842.7 сая төгрөг бүрдүүлэхээр төлөвлөж, 932.6 сая төгрөг бүрдүүлсэн байна.

Орхон аймаг болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Эрдэнэт үйлдвэрээс аймгийн ОНХС-д 2,800.0 сая төгрөг олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 2,600.0 сая төгрөг олгосон байна.

Аймгийн баяр наадмын худалдаа, үйлчилгээний орлогоос аймгийн ОНХС-д 7.0 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж бүрэн бүрдүүлсэн, Баян-Өндөр сумын ОНХС-д иргэдийн бүлгээр 2017 онд гүйцэтгэсэн ажлын урьдчилгаа санхүүжилтийн 1.2 сая төгрөгийг Шүүхийн шийдвэрээр буцаан төлүүлсэн байна.

Сумдын ОНХС-д малын тоо толгойн албан татварт 60.4 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр Жаргалант сумын малын тоо толгойн албан татварын 37.4 сая төгрөг бүрэн төвлөрсөн байна.

1.2 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө сумдын саналын жагсаалтыг авч эрэмбэлээгүй байна.

1.2.1 ОНХС-ийн төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа хангалтгүй, иргэдийн санал аваагүй зарим ТАХ-г төлөвлөж, ИТХ-аар баталсан байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог хангах, тухайн ТАХ-ний ач холбогдол, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлэх талаар Төсвийн тухай хуулийн 63.1⁷, 63.2⁸, 63.3⁹ дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын Тав¹⁰, Зургаа¹¹ дугаар зүйлд заасны дагуу багийн түвшинд иргэдээс батлагдсан маягтын дагуу саналыг авч, багийн ИНХ-аар хэлэлцүүлэн эрэмбэлэн сумын ЗДТГ-т хүргүүлж, сумын Засаг дарга нарын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ТАХ-ний саналыг нэгтгэн, эрэмбийг танилцуулж, хэлэлцэн баталсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.5¹²-д заасны дагуу урьдчилсан жагсаалт боловсруулж, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй,

⁷ Төсвийн тухай хуулийн 63.1-д “Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна”

⁸ Төсвийн тухай хуулийн 63.2-д “Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны ИНХ-д гарсан саналыг ИНХ хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно”

⁹ Төсвийн тухай хуулийн 63.3-д “Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”

¹⁰ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын “Тав. Баг, хорооны түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх”

¹¹ Дээрх журмын “Зургаа. Сум, дүүргийн түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх”

¹² Дээрх журмын 7.5-д “Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна”

аймгийн төвийн Баян-Өндөр сумын авсан иргэдийн саналыг харгалзан аймаг орон нутгийн төсөв боловсруулах үйл явцтай хамт төлөвлөсөн байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр тусгасан ТАХ-үүдээс дараах ажлууд иргэдийн саналаар гарч эрэмбэлэгдээгүй байна.

Баян-Өндөр сумын хувьд:

- Зэст багийн иргэний танхимд бараа материал худалдан авах
- Оюут багийн иргэний танхимын тохижилт
- Урт булаг багийн иргэний танхимд бараа материал худалдан авах
- Яргуйт багийн иргэний танхимд бараа материал худалдан авах
- Баян-овоот багийн иргэний танхимд бараа материал худалдан авах
- Шанд багийн байрны засвар, тохижилт
- Их залуу багийн байрны засвар, тохижилт
- Булаг багийн байрны гадна талбайн засвар тохижилт
- Оюут багийн 28-р байрны орцны засвар хийх
- Уурхайчин багт камержуулалт нэмэгдүүлэх
- Хүрэн булаг багийн 19-р цэцэрлэгт хүүхдийн хувцасны шүүгээ авах
- Баянбулаг багийн 27-р цэцэрлэгт бараа материал худалдан авах
- Наран багийн 3-р сургуульд бараа материал худалдан авах
- Баянцагаан - 18-р сургууль тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах
- Баянцагаан - 24-р цэцэрлэгт тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах
- Бүрэн бүст баг 5-12 байрны гадна сагсан бөмбөгийн талбай засварлах
- Согоот багийн гэрэлт самбар хийх
- Эрдэнэ багийн 6 гудамжны хүүхдийн тоглоомын талбайд хашлага хийх
- Эрдэнэ багийн 2,25 гудамжны үзүүрт гүүрэн гарц байгуулах
- Баянбулаг - Төрийн үйлчилгээг иргэдэд таниулах, оролцоог нэмэгдүүлэх сургалт
- Цагаанчулуут - Төрийн үйлчилгээг иргэдэд таниулах, оролцоог нэмэгдүүлэх сургалт
- Рашаант багт хүлэмж худалдан авах
- Цагаанчулуут баг-Хуучин цамхагт гэрэлтүүлэг, камержуулалт хийх
- 7-хорооллын хүүхдийн тоглоомын талбай засварлах
- Уртын гол баг Хуванцар хог хаягдал цуглуулах сав худалдан авах
- Даваат багт гэрэлтүүлэг хийх
- Хүлэмжийн газарт хашаа болон 6/0кв ЦДАШ
- Баян-өндөр суманд шаардлагатай тоног төхөөрөмж бараа материал авах
- Баян-өндөр сумын нөөцийн өвсний саравчны суурь засварлах
- Баян-өндөр суманд шарилж устгалын хадуур худалдан авах
- Баян-өндөр сумын гамшгийн бэлэн байдлын үеийн бараа материал авах
- Баян-өндөр сумын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах
- Баян-өндөр сумын спорт заланд шаардлагатай хэрэглэгдэхүүн худалдан авах
- Багуудын ажлын албаны өвлийн бэлтгэл ажлын хүрээнд бараа материал худалдан авах
- Малын угаалга хийх хашаа худалдан авах

Жаргалант сумын хувьд:

- Сумын Засаг даргын Тамгын газрын хурлын заал болон урд хэсгийн дулааны шугам засварлах
- 2-р байрны дээврийн засвар
- Жаргалант багийн үерт эвдэрсэн замын засвар
- Гүний худгийн цахилгаан үүсгүүр
- Цэцэрлэгийн үүдний болон хүлээлгийн өрөөний дотор болон дээврийн засвар
- Цэцэрлэгийн гадна хаалга солих болон сумын төвийн гэрэлтүүлэг солих
- Ахмадын автобус
- Татварын өрөөний их засвар, нийгмийн даатгалын өрөөний цонх солих
- Иргэн Дугарт дугуй засварын тоног төхөөрөмж
- Улаантолгой багийн үер эвдэрсэн зам

- Сургуулийн дотуур байрны паар солих
- Өвлийн улиралд зам даваа засахад шаардлагатай шатах тослох материал

Орхон аймгийн хүн амын 2022 оны статистик тоо мэдээгээр 20-оос дээш насны 65,908 иргэн байгаагаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-нд нийт 8,884 иргэнээс санал авч эрэмбэлсэн байна.

Хүснэгт 7. Орхон аймгийн 20-оос дээш насны хүн амын тоо, ОНХС-д санал өгсөн иргэдийн тоо.

Баг, хороо	20-оос дээш насны хүн амын тоо	ОНХС-аар хэрэгжүүлэх ТАХ-д санал өгсөн иргэний	
		тоо	Хувь
Баян-Өндөр сум	63,657.0	7,077.0	11.1%
1-р баг, Зэст	3,381.0	111.0	3.3%
2-р баг, Оюут	3,791.0	289.0	7.6%
3-р баг, Уурхайчин	3,778.0	528.0	14.0%
4-р баг, Хүрэнбулаг	3,947.0	336.0	8.5%
5-р баг, Уртбулаг	3,067.0	157.0	5.1%
6-р баг, Согоот	3,515.0	612.0	17.4%
7-р баг, Дэнж	3,663.0	226.0	6.2%
8-р баг, Бүрэнбүст	2,671.0	112.0	4.2%
9-р баг, Шанд	1,614.0	265.0	16.4%
10-р баг, Наран	2,272.0	245.0	10.8%
11-р баг, Цагаанчулуут	4,782.0	325.0	6.8%
12-р баг, Булаг	1,826.0	95.0	5.2%
13-р баг, Баянцагаан	3,180.0	324.0	10.2%
14-р баг, Говил	2,074.0	222.0	10.7%
15-р баг, Рашаант	2,718.0	303.0	11.1%
16-р баг, Малчин	372.0	160.0	43.0%
17-р баг, Эрдэнэ	4,405.0	945.0	21.5%
18-р баг, Баянбулаг	1,896.0	300.0	15.8%
19-р баг, Их залуу	2,485.0	186.0	7.5%
20-р баг, Даваат	2,541.0	502.0	19.8%
21-р баг, Уртын гол	1,877.0	184.0	9.8%
22-р баг, Яргуйт	3,802.0	650.0	17.1%
Жаргалант сум	2,251.0	1,807.0	80.3%
1-р баг, Улаантолгой	708.0	573.0	80.9%
2-р баг, Жаргалант	787.0	630.0	80.1%
3-р баг, Дулаан-Уул	756.0	604.0	79.9%
Нийт дүн	65,908.0	8,884.0	13.5%

Эндээс харахад аймгийн төвийн Баян-Өндөр сумын хувьд хөдөлмөрийн насны иргэдийн 11 хувиас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхөд санал авсан нь санал асуулгыг иргэдэд хүртээмжтэй, олон нийтийг хамруулж зохион байгуулаагүй, нөгөө талаар иргэд, олон нийтийн ойлголт муу, мэдээлэл дутмаг, идэвх оролцоо хангалтгүй байна.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.5¹³, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны

¹³ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.5-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ”

журам"-ын 4.3.2¹⁴ дахь заалтыг мөрдөж ажиллаагүй, сумдаас санал авч урьдчилсан жагсаалт боловсруулан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй зөрчилд холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүллээ.

1.2.2 Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим ТАХ-г төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулаагүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 17,544.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 ТАХ-г хэрэгжүүлэхээр 2023 онд 11,297.5 сая төгрөг төлөвлөж аймгийн ИТХ-аас¹⁵ тодотгож баталсан байна.

Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 5,413.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 135 ТАХ-г хэрэгжүүлэхээр 2023 онд 4,413.9 сая төгрөг төлөвлөж сумын ИТХ-аас¹⁶ тодотгож баталсан байна.

Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 7,607.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 109 ТАХ-г хэрэгжүүлэхээр 2023 онд 4,969.1 сая төгрөг төлөвлөж сумын ИТХ-аас¹⁷ тодотгож баталсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлууд нь Орхон аймаг, Эрдэнэт хотын “Ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2025”¹⁸, Орхон аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл¹⁹, аймгийн Засаг даргын 2020-2024²⁰ оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан байна.

Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ТАХ нь сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй байна. Үүнд:

- Баян-Өндөр суманд шарилж устгалын хадуур худалдан авах
- Баян-Өндөр суманд шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах
- Багуудын ажлын албаны өвлийн бэлтгэл ажлын хүрээнд бараа материал худалдан авах
- Оюу багийн иргэний танхимын тохижилт
- Яргуйт багийн иргэний танхимын тохижилт
- Шинээр үүссэн багуудын иргэний танхимын тохижилт
- Зэст багийн иргэний танхимд бараа, материал худалдан авах
- Уртбулаг багийн иргэний танхимд тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах
- Баян-Овоот багийн иргэний танхимын тоног төхөөрөмж худалдан авах
- Булаг багийн байрны засвар
- Шанд багийн байрны засвар, тохижилт

¹⁴ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх”

¹⁵ Аймгийн ИТХ-н 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Ээлжит бус XII хуралдааны 12/02 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

¹⁶ Баян-Өндөр сумын ИТХ-н 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн Ээлжит XIV хуралдааны 14/02 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт, мөн 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Ээлжит XV хуралдааны 15/07 дугаар тогтоол

¹⁷ Жаргалант сумын ИТХ-н 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн Ээлжит бус I хуралдааны 01 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

¹⁸ Аймгийн ИТХ-н 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 13/01 дүгээр тогтоол

¹⁹ Аймгийн ИТХ-н 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Ээлжит II хуралдааны 02/01 дүгээр тогтоол

²⁰ Аймгийн ИТХ-н 2020 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн Ээлжит II хуралдааны 02/02 дугаар тогтоол

- Их залуу багийн байрны засвар, тохижилт

Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалтад болзошгүй аваарын зардалд 209.0 сая төгрөг баталж, шууд худалдан авалтаар нийт 12²¹ ажилд 204.8 сая төгрөг зарцуулсан нь сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй байна.

1.2.3 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд 283 ТАХ-г 20,680.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсны 13,591.1 сая төгрөгийн 157 ТАХ нь шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ байна.

Аймгийн болон сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх ТАХ нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 8. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ. /сая.төгрөг/

Д/д	Аймаг, сум	Шилжих ХО		Шинээр эхлэх ХО		Төсөл хөтөлбөр		Нийт дүн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн ОНХС	9	4,425.1	28	6,515.5	2	357.0	39	11,297.5
2	Баян-Өндөр сумын ОНХС	55	1,888.1	77	2,465.8	3	60.0	135	4,413.9
3	Жаргалант сумын ОНХС	50	94.0	52	4,609.8	7	265.2	109	4,969.1
Нийт дүн		114	6,407.2	157	13,591.1	12	682.2	283	20,680.5

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шилжих хөрөнгө оруулалтын 105 ТАХ-ний 103 нь өмнөх онуудад гүйцэтгэсэн ажлын баталгааны 5 хувь болон үлдэгдэл санхүүжилтийн төсвийг баталсан ТАХ байна.

Аймгийн ОНХС-ийн төлөвлөгөөнд зураг төсөвгүй Согоот багийн нутаг дэвсгэрийн орчныг сайжруулах тохижилт – 245.0 сая төгрөгийн ажил төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29.4²²-д заасныг зөрчиж байна.

1.2.4 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хууль, журмаар тогтоосон чиг үүрэгт хамаарах ТАХ-г хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3²³ дахь хэсэгт заасан ОНХС-ийн хөрөнгийг зарцуулахыг хориглосон зүйлд хамаарах ТАХ-г аймаг, сумын ОНХС-ийн төлөвлөлтөд тусгаагүй байна.

²¹ Энэхүү 12 ажлын мэдээллийг тайлангийн 1.2.1 дэх хэсэгт Жаргалант сумын иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй ажлын жагсаалтад тусгасныг харна уу.

²² Төсвийн тухай хуулийн 29.4-д "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана."

²³ Төсвийн тухай хуулийн 60.3-д "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно", 60.3.1-д "орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ", 60.3.2-д "улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага", 60.3.3-д "үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал", 60.3.4-д "нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа", 60.3.5-д "зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах"

Бүлэг 2

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь тодорхой асуудлуудыг шийдэж буй боловч нийтийн эзэмшлийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй, цаг хугацаандаа хэрэгжүүлж дуусгахад анхаарах шаардлагатай байна.

2.1 ОНХС-ийн хөрөнгөөр ТАХ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийн зарим заалтыг зөрчсөн байна.

2.1.1 Сангийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн зарим заалтуудыг зөрчин зохион байгуулсан байна.

Аймгийн хэмжээнд 2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 157, төсөл хөтөлбөрийн 2 нийт 16,386.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 159 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар баталсан байна. Эдгээрээс аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 245.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ¹²⁴ ТАХ-ний зураг төсөв ирээгүй тул ХАА-г зохион байгуулаагүй, 325.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ²²⁵ ТАХ-ний тендер шалгаруулалтад нэг ч компани оролцоогүй тул амжилтгүй болсон байна.

Хүснэгт 9. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга. /сая.төгрөг/

№	Аймаг, сумын нэр	Зохион байгуулсан ХАА-ны тоо		Үүнээс							
				Нээлттэй тендер шалгаруулалт		Шууд худалдан авалт		Харьцуулалт		Бусад	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сум	53	7,253.3	6	6,073.7	34	507.1	12	627.5	1	45.0
2	Баян-Өндөр сум	78	2,515.8	3	340.0	38	634.1	33	1,479.2	4	62.5
3	Орхон аймаг	27	6,372.3	18	5,864.8			9	507.6		
Нийт дүн		158	16,141.4	27	12,278.5	72	1,141.2	54	2,614.3	5	107.5

Үүнээс Баян-Өндөр сумын 62.5 сая төгрөгийн 4 ТАХ-г олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаагаар, Жаргалант сумын 45.0 сая төгрөгийн 1 ТАХ-г гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулсан байна.

Аудитаар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний ХАА-г санамсаргүй түүврээр сонгон шалгахад дараах нийтлэг зөрчил илэрлээ.

Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж, ижил төстэй гэрээний туршлага, гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээг тухайн төсөл, арга хэмжээний шинж чанар, нөхцөл байдал, төсөвт өртөг, хугацаа, худалдан авах ажиллагааны төрөл, хэлбэрээс харилцан хамааралгүй, 50 эсвэл 100 хувиар ТББ-т шаардсан, эсвэл чадавхыг үнэлэхэд ач холбогдолгүй, давхардсан баримт шаардсан.

Оны эхэнд зарласан ТББ-үүдэд тусгасан одоо хийж байгаа, хийхээр төлөвлөсөн ажлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, дуусаагүй ажилтай бол тайлбар

²⁴ Согоот багийн нутаг дэвсгэрийн орчныг сайжруулах тохижилтын ажил – 245.0 сая төгрөг

²⁵ Кувейтын гудамжинд байрлалтай төв цэвэр усны шугамын ажил – 125.0 сая төгрөг, Төлбөр хураах цэгийг нүүлгэх шилжүүлэх – 200.0 сая төгрөг

болон ажлын гүйцэтгэлийн талаарх захиалагчийн тодорхойлолт, дуусаагүй ажлын гүйцэтгэл нь 70 хувиас багагүй байх ба инженер техникийн ажилтнууд нь давхцахгүй байх, давхацсан тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болох тухай шаардлагыг ижил төстэй олон ажилд зэрэг шалгарсан компанид харгалзан үзээгүй, амжилтгүй болсон тендерийг дахин зарлахдаа болон ижил төстэй дараагийн ажлын тендерийг зарлахдаа ТББ-т тусгаагүй зэрэг нь ТБОНӨХБАҮХАТухай /хуучин/ хуулийн 6.126-д заасантай нийцэхгүй байна. Үүнд:

- *Дэнж багийн сайжруулсан зам хийх – 148.0 сая, Эрдэнэ багийн сайжруулсан зам хийх – 250.0 сая төгрөгийн ажлын тендерийг 2 удаа зохион байгуулж гүйцэтгэгчээр 1 компани шалгарсан. Энэхүү 2 ажлын тендерийг эхний удаа зарласан ТББ-т борлуулалтын орлогын дундаж, ижил төстэй гэрээний туршлага, мөнгөн хөрөнгийн хэмжээг төсөвт өртгийн 50 хувиар шаардсан бол 2 дахь удаа зарласан ТББ-т өмнөх тендер амжилтгүй болсон шалтгаантай огт хамааралгүй дээрх борлуулалтын орлогын дундаж, ижил төстэй гэрээний туршлага, гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээг төсөвт өртгийн 100 хуваарь шаардахаар үнэлгээний хорооны нарийн бичгийн саналаар тусгасан. Гүйцэтгэгч нь эхний удаагийн шалгаруулалтад хамт оролцсон бусад ААН-ээс хамгийн өндөр үнийн санал өгсөн бөгөөд аудитын дүгнэлт шаардлага хангахгүй, талбайн инженер, ХАБЭА-н ажилтны ажилласан жилийг нотлох баримт ирүүлээгүй, ЗТХЗ, ЗТЗ-ийг хяналтын төсөвт тооцооноор тусгаж ирүүлээгүй шалтгаанаар хасагдсан бол, 2 дахь удаагийн шалгаруулалтад ЗТХЗ, ЗТЗ-ийг хяналтын төсөвт тооцооноор тусгаснаас өөрөөр үнийн саналд өөрчлөлт оруулаагүй.*
- *Их залуу багийн сайжруулсан зам хийх – 365.0 сая төгрөгийн ажлын тендерт дээрх Дэнж болон Эрдэнэ багийн сайжруулсан зам хийх ажлын тендерт шалгарсан компани мөн шалгарсан. ТББ-т борлуулалтын орлогын дундаж, ижил төстэй гэрээний туршлага, мөнгөн хөрөнгийн хэмжээг төсөвт өртгийн 100 хувиар шаардсан, одоо хийж байгаа ажил болон хийхээр төлөвлөсөн, дуусаагүй ажлын мэдээлэл ирүүлэх, инженер техникийн ажилтан давхардсан тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно гэсэн заалтыг ТББ-т тусгаагүй.*
- *Яргуйт багийн сайжруулсан зам хийх – 398.1 сая, Баянцагаан багийн сайжруулсан зам хийх – 248.5 сая, Рашаант багийн сайжруулсан зам хийх – 399.7 сая, Ундрагын 3-р гудамж 17-р сургуулийн ар тал Соёлын төвийн дэргэд авто зогсоол хийх – 171.0 сая төгрөгийн ажлын тендерүүд нэг компани гүйцэтгэгчээр зэрэг шалгарсан. Тус компанийн бэлтгэж ирүүлсэн ТББ-т өөрсдийн нь тодорхойлсноор 37-оос 78.5 хувийн гүйцэтгэлтэй хамгийн сүүлийнх нь 2022.11.20-ний өдөр дуусах байсан боловч 2023.11.01-өдрийн хүртэл сунгасан 4 дуусаагүй ажилтай байна. Гэтэл 2023.01.10-ны өдөр зарласан эдгээр ажлуудын ТББ-т одоо хийж байгаа, хийхээр төлөвлөсөн ажлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, дуусаагүй ажилтай бол тайлбар болон ажлын гүйцэтгэлийн талаарх захиалагчийн тодорхойлолт, дуусаагүй ажлын гүйцэтгэл нь 70 хувиас багагүй байх ба инженер техникийн ажилтнууд нь давхцахгүй байх, давхацсан тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болох тухай шаардлага тусгасан боловч компанийн инженер техникийн ажилчид давхацсан байна. Мөн ТББ-т харилцагч банк тус бүрээс тодорхойлолт авч ирүүлэх талаар тусгасан. Тус компани нь Голомт банк, Төрийн банк, ХХБ-д нийт 4 данстай бөгөөд ТББ-д зөвхөн ХХБ-ны 1 дансанд тодорхойлолт лавлагаа авч ирүүлсэн байхад шалгарсан байна.*

²⁶ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн /хуучин/ 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална". 2023.06.16-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг /шинэчилсэн найруулга/ 2024.01.01-өдрөөс эхлэн дагаж мөрдсөнөөр хүчингүй болсон.

- Шанд багийн сайжруулсан зам хийх -450.0 сая төгрөгийн ажилд дээрх 4 замын ажилд зэрэг шалгарсан компани гүйцэтгэгчээр шалгарсан. Дээрх 4 замын ажлын гүйцэтгэгч шалгарснаас хойш энэхүү ажлын тендер зарлагдсан бөгөөд ТББ-т борлуулалтын орлогын дундаж, ижил төстэй гэрээний туршлага, мөнгөн хөрөнгийн хэмжээг төсөвт өртгийн 100 хувиар шаардсан, одоо хийж байгаа ажил болон хийхээр төлөвлөсөн, дуусаагүй ажлын мэдээлэл ирүүлэх, инженер техникийн ажилтан давхардсан тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно гэсэн заалтыг тусгаагүй тул тус компани шалгарсан байна.

Аймгийн ОНӨГ-аас Баян-Өндөр сумын хэрэгжүүлсэн ТАХ нь худалдан авах ажиллагааны хууль, журмын дагуу явагдсан эсэх, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, тендерийн баримт бичгийн иж бүрдэл бүрэн эсэхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмж хүргүүлэх зорилгоор хийсэн шалгалтаар дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийг Сангийн сайдын 2021 оны “Журам батлах тухай” 103²⁷ дугаар тушаалын хавсралтаар баталсан жишиг маягтын дагуу үйлдээгүй. Наран баг.22-32 дугаар гудамжны төв зам дагуух гэрэлтүүлэг хийх ажил, Уурхайчин баг. 3-16, 20 дугаар байранд явган хүний зам хийх, Уртын гол багт хогны пункер худалдан авах, Рашаант багт хогны пункер худалдан авах ажлууд
- Тендер нээсэн өдрийн байдлаар хянан үзэх шатны үнэлгээний хорооны хурлыг хийгээгүй. Уртын гол багт хогны пункер худалдан авах, Рашаант багт хогны пункер худалдан авах ажлууд
- Үнийн санал судалсан эх үүсвэрийг баримт бичигт хавсаргаагүй, бараа хүлээн авах комисст аймгийн ОНӨГ-аас мэргэжилтэн томилж ажиллуулаагүй, хугацаандаа нийлүүлэгдсэн эсэх нь тодорхойгүй. Спорт зааланд шаардлагатай хэрэглэгдэхүүн худалдан авах, Баянбулаг багийн 27 дугаар цэцэрлэгт бараа, материал худалдан авах
- Уурхайчин баг. 3-16, 20 дугаар байранд явган хүний зам хийх ажил дээр 2023.04.06-ний өдөр гүйцэтгэгчээр шалгарсан компани уг ажлыг гүйцэтгэх боломжгүй талаар бичиг ирүүлэхэд тендер хүчинтэй байх хугацаа 2023.04.28-ны өдөр дууссанаас хойш үнэлгээний хороо 2023.05.22-нд дахин хуралдаж шаардлагад нийцээгүй гэж анх үнэлсэн компанийг 2023.05.26-ний өдөр шалгаруулж, 2023.05.30-ний өдөр гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТухай /хуучин/ хуулийн 29.2²⁸-д заасныг зөрчсөн.
- Цэцэрлэгийн барилга 150 ор/Орхон, Баян-өндөр сум/ гадна тохижилт ажлын ТББ-т борлуулалтын орлогыг сүүлийн 3 жилээр /2020,2021,2022/ шаардсан боловч уг тендерт шалгарсан гүйцэтгэгчийн санхүүгийн лавлагаанд 2020 оны мэдээлэл байхгүй байхад шаардлага хангасан гэж үнэлсэн, Тусгай зөвшөөрөл, инженер техникийн ажилчдын диплом, автомашины лавлагааг цахим системээр татаагүй, Тендер хянан үзэх маягт6 маягтыг гишүүн бүрээр бөглүүлээгүй, Дахин үнэлгээ хийсэн үнэлгээний хорооны хурлын зөвлөмж, тайланг захиалагчид хүргүүлээгүй байна.

Жаргалант сумын 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны 5 ажилд тендерт оролцогчдоос Сангийн яаманд гомдол гарган хянуулж, Сангийн яам бүгдэд нь

²⁷ Сангийн сайдын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/254 дугаар тушаалаар 2024.01.01-ний өдрөөс хойш хүчингүй болсон.

²⁸ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн /хуучин/ 29.2-д “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй өдрийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна” – Энэ хуулийг 2024.01.01-ээс хүчингүй болсонд тооцсон.

захиалагчийн шийдвэр үндэслэлгүй тул хүчингүй болгож, тендерийн үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх эсхүл тендер шалгаруулалтыг хуульд нийцүүлэн дахин зохион байгуулахыг мэдэгдсэн байна.

Дээрх зөрчлүүдтэй холбогдуулан сумдын Засаг дарга нарт болон аймгийн ХАА-ны газарт хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.1.2 Жаргалант сумын ОНХС-д болзошгүй аваарын зардал 209.0 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 204.8 сая төгрөг зарцуулсан байна.

Аймгийн ИТХ-ийн 2023.10.03-ний өдрийн “Аймгийн 2023 оны төсөвт зохицуулалт хийх тухай” 12/02 дугаар тогтоолоор өмнө нь ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалтад баталсан 725.0 сая төгрөгийн 5 ажлыг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шилжүүлэн баталсан байна. Үүнд:

- 1 4-14, 16, 18, 20-ын арын замыг тусгаарлах тэмдэг тэмдэглэгээ хийх – 50.0 сая төгрөг. /2023.05.08-ний өдөр гэрээ байгуулсан./
- 2 Согоот багийн нутаг дэвсгэрийн орчныг сайжруулах тохижилтын ажил – 245.0 сая төгрөг. /Зураг төсөвгүй тул ХАА зохион байгуулаагүй./
- 3 Чийрэгжүүлэлтийн талбай байгуулах – 155.3 сая төгрөг. /ХАА-г 2023.08.11-ний өдөр анх, 2023.09.25-ний өдөр дахин зарлаж, 2023.10.31-ний өдөр гэрээ байгуулсан./
- 4 Төлбөр хураах цэгийг нүүлгэх шилжүүлэх – 200.0 сая төгрөг. /2023.04.20, 2023.06.22-ний өдөр ХАА-г зарлаад тендерт нэг ч оролцогч оролцоогүй. Дахин зарлаагүй./
- 5 Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангуулах, аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг бүрдүүлэх - 75.0 сая төгрөг. /2023.03.30-нд гэрээ байгуулсан./

Жаргалант сумын ОНХС-ийн жагсаалтад болзошгүй аваарын зардал 209.0 сая төгрөг баталж, тухай бүр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан нийт 204.8 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 10. Болзошгүй аваарын зардалд баталсан төсвийн зарцуулалт. /сая.төгрөг/

Д/д	Бэлтгэн нийлүүлэгч	Олгосон санхүүжилт	Гүйлгээний утга
1	МТ ХХК	10.0	Үер усны улмаас гэмтсэн зам засвар шатах тослох материал
2	Э.Пүрэвдорж	7.3	Хурлын заалны халаалт
3	Т.Шижир-Алт	10.0	Цахилгаан мотор
4	Б.Банзрагч	7.5	Дугуй засвар иж бүрэн тоног төхөөрөмж
5	Баасанжаргал	20.0	48 хүний ахмад автобус худалдан авах
6	Б.Баасандалай	19.7	Татвар НД өрөөний засварын материал
7	МТ ХХК	10.0	Улаантолгой багийн үерийн зам засах шахахуун зардал
8	Э.Пүрэвдорж	4.0	ЗДТГ-ын хурлын заалны халаалт сайжруулах
9	Их мэргэд домог ХХК	8.0	3-р цэцэрлэг үүдний засвар
10	Ижилхэн	12.1	3-р цэцэрлэг хаалга, сумын төвийн гэрэлтүүлэг
11	Мэргэн гүн хийморь ХХК	80.0	2-р байрны дээвэр засвар
12	Макс строй ХХК	8.3	Дотуур байрны паар засвар
13	МТ ХХК	7.8	Зам гаргах шатахуун
Дүн		204.8	

Болзошгүй аваарын зардлын төсөв нь сумын ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдаагүй, ХАА-г хууль, журмын дагуу зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24.4²⁹, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын 8.7³⁰ дахь хэсгийг зөрчсөн байна.

Баян-Өндөр сумын ЗДТГ-ын худалдан авалттай холбоотой 13.0 сая төгрөгийг 2023.06.02-ний өдөр Баян-Өндөр сумын ОНХС-ийн данснаас шилжүүлснийг залруулж 2023.12.19-ний өдөр Баян-Өндөр сумын ЗДТГ-с ОНХС-ийн дансандаа буцаан шилжүүлсэн байна. Мөн Жаргалант сумын ОНХС-н данснаас 2023.12.08-нд 13.0 сая төгрөгийг андуурч зарцуулсныг Жаргалант сумын ЗДТГ-аас буцаан шилжүүлсэн байна.

Дээрх болон аймгийн ОНХС-ийн хөрөнгийн санхүүжилтийн эрхийг аймгийн ЗДТГ-н СТСХ-ээс олгож байгаа нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын 8.5³¹ дахь заалттай, сумдын ОНХС-н төлбөрийн хүсэлтэд 2-р гарын үсгийг санхүүгийн албаны дарга нар зурж буй нь журмын 8.6³² дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг аймгийн хэмжээнд нэгтгэн судалж, тооцоогүй байна.

2.2.1 Өмнөх онуудад төлөвлөсөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй зарим ТАХ-г хугацаанд нь ашиглалтад оруулаагүйгээс бодит үр дүн гарахгүй байна.

Аймгийн ОНХС-ийн шилжих хөрөнгө оруулалтын жагсаалтад 2021 онд эхлээд 2022 онд дуусах нийт 7 багт “Миний гудамж-бидний гэр” төслийн хүрээнд гэр хороололд баригдсан цэвэр, бохир усны төв шугамаас салбар шугам сүлжээ татах ажил батлагдаж, 2023 оны төгсгөлд 5 багийн ажил дуусаж, 2 багийн ажил 2024 онд дамжин хэрэгжихээр болсон байна.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, аймгийн, сумдын Засаг дарга нар нь сумын ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний тоон болон чанарын хүрэх үр дүнг нэгтгэн тооцоогүй байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г хэт жижиглэж, олон арга хэмжээ болгож хуваан баталж байгаа нь ОНХС-ийн хөрөнгө оруулалтын үр ашиг, өр өгөөжийг бууруулж байна.

²⁹ Төсвийн тухай хуулийн 24.4-д “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”

³⁰ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.7-д “ОНХС-ийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24.4-т заасны дагуу төсвөөс санхүүжилт олгохгүй байх үндэслэл болно”

³¹ Дээрх журмын 8.5-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно.”

³² Дээрх журмын 8.6-д “Энэхүү журмын 8.5-д заасан санхүүжилтийн эрхийн дагуу ОНХС-ийн төрийн сан дахь данснаас гүйлгээ хийх төлбөрийн хүсэлтийн баримтад аймаг, нийслэлийн хувьд 1 дүгээр гарын үсгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч, сум дүүргийн хувьд 1 дүгээр гарын үсгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг Засаг даргын Тамгын газрын ахлах нягтлан бодогч тус тус зурна.”



Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хийгдсэн гүүрэн гарцын ажлыг бүрэн төлөвлөөгүйгээс борооны ус бетон хоолойгоороо биш зам дээгүүр гарцын 2 талаар урсаж гүүрэн гарцыг эвдрэлд оруулсан байна.


Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 8 багт 2,529.3 сая төгрөгөөр сайжруулсан зам хийх төсөв баталж, хэрэгжүүлсэн байна. Сайжруулсан зам нь тухайн гудамжны иргэдэд хэрэгтэй боловч, байгаль, цаг уурын нөхцөл байдалд тэсвэргүй, урт хугацаандаа үр дүн өгөхөөргүй төсөл арга хэмжээ болон хувирч байна.

2.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн томоохон төсөл арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахаар байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн томоохон ТАХ-үүд нь орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахаар байна. Тухайлбал:

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн “Миний гудамж-бидний гэр” төслийн хүрээнд гэр хороололд баригдсан цэвэр, бохир усны төв шугамаас салбар шугам сүлжээ татах ажлууд, Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд орон сууцжуулахад шаардлагатай КТП, ТП барих ажил.

Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2022-2023 онд хэрэгжүүлсэн анх удаа орон нутагт 150 хүүхдийн ор бүхий цэцэрлэгийн барилга барьж ашиглалтад оруулсан нь үр дүнтэй хөрөнгө оруулалтын ажил болсон байна.



Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн бусад ТАХ-үүд нь сумын хөгжилд өнгө үзэмж нэмсэн тохижилт, гэрэлтүүлэг, засварын ажлууд голлон хийгдсэн байна.

Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн ТАХ-үүд нь төсвийн байгууллагуудын байрны засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж худалдан авахад болон хөдөө аж ахуйн салбарт чиглэсэн ажлууд хийгдсэн байна.

Жаргалант сум мал аж ахуй, газар тариалангийн зориулалтаар ОНХС-ийн 2023 оны хөрөнгө оруулалтаар 128.9 сая төгрөгөөр - Трактор, 278.5 сая төгрөгөөр Хогны хово автомашин, Жаргалантын ногоочид хөтөлбөрийн хүрээнд 62.8 сая төгрөгөөр хөдөө аж ахуйн багаж, техник хэрэгсэл худалдан авсан байна.



Иргэдийн ногоо тарих, хураах ажилд хөдөө аж ахуйн трактор, дагалдах техник, тоног төхөөрөмжүүдээр үйлчлэн, ажиллаж байгаа нь хэрэгцээ, шаардлагыг хангаж байна.

2.3 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон зарим ТАХ нь хугацаандаа бүрэн ашиглалтад ороогүй, гэр хороололд тавигдсан шугам сүлжээнд холбогдох айл, өрхийн идэвх, оролцооноос хамаарч ОНХС-аар хэрэгжүүлсэн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.

2.3.1 Төлөвлөсөн ажлуудыг цаг хугацаанд нь бүрэн ашиглалтад оруулахад хяналт, шахалт тавьж ажиллах шаардлагатай байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд бүрэн хэрэгжиж дууссан ТАХ-г зориулалтын дагуу хэвийн ашиглаж байна.

Дэд бүтцийн ажлуудад хийгдсэн хөрөнгө оруулалтын ашиглалт нь тухайн байршилд оршин суух айл, өрхийн идэвх санаачилгаас хамаарах бөгөөд тухайлбал “Миний гудамж – бидний гэр” төслийн хүрээнд нийт 7 багийн 8,548 өрхөөс 1,245 өрх инженерийн шугам сүлжээнд холбогдох боломжтойгоос 2023 онд хэрэгжиж дууссан 5 багийн иргэдээс 2023 онд 113 өрх, 2024 онд 253 өрх холбогдож, инженерийн шугам сүлжээний ашиглалт 20 гаруй хувьтай байна.

Хүснэгт 11. Орхон аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт. /сая.төгрөг/

№	Аймаг, сумын нэр	Гэрээ байгуулсан, ТАХ		Бүрэн хэрэгжсэн ТАХ		Дутуу хэрэгжсэн ТАХ		Хэрэгжээгүй ТАХ	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Баян-Өндөр сум	80	2,382.1	73	2,046.3	5	264.5	2	71.3
2	Жаргалант сум	59	7,294.7	57	2,529.9	1	4,763.6	1	1.2
3	Орхон аймаг	35	9,278.2	26	5,513.4	6	3,478.2	3	286.6
Нийт дүн		174	18,955.0	156	10,089.6	12	8,506.3	6	359.1

Нэгдсэн судалгаанаас харахад аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн 359.1 сая төгрөгийн 6 ТАХ огт хэрэгжээгүй, 8,506.3 сая төгрөгийн 12 ТАХ дутуу хэрэгжсэн, 10,089.5 сая төгрөгийн 156 ТАХ бүрэн хэрэгжиж дууссан байна.

Дутуу хэрэгжсэн ТАХ-ээс Жаргалант сумын ОНХС-ийн 4,763.6 сая төгрөгийн 1³³ ТАХ нь 2023-2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил байна.

Орхон аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Зүүн дэнж, Рашаант багийн “Миний гудамж – бидний гэр” төсөл, Орхон аймаг дахь орон сууцны 1А хорооллын дэд бүтэц барих ажил он дамжин дутуу хэрэгжсэн нь гүйцэтгэгч цаг хугацаанд нь хэрэгжүүлж ашиглалтад өгөөгүйтэй холбоотой байна.

Харин ХАА-г оройтож зарласан, тендер амжилтгүй болж олон дахин зарласан зэргээс хамаарч оны эцэст гэрээ байгуулсан тул тухайн ондоо огт хэрэгжээгүй дараах ажлууд байна. Үүнд:

- Цагаан тоосны дэгдэлтийн нөлөөллөөс тоосны бүсэд амьдарч буй иргэдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах зардал – 35.0 сая төгрөг
- Нэг цонхны үйлчилгээний төвийг засварлаж "Цахим төв" болгох /Эрдэнэт үйлдвэрийн хамтын ажиллагааны хүрээнд/ - 96.9 сая төгрөг
- Чийрэгжүүлэлтийн талбай байгуулах – 154.6 сая төгрөг
- Багуудын ажлын албаны өвлийн бэлтгэл ажлын хүрээнд бараа материал худалдан авах – 52.3 сая төгрөг /Баян-Өндөр сумын ОНХС/
- Рашаант багт хүлэмж худалдан авах – 19.0 сая төгрөг /Баян-Өндөр сумын ОНХС/

2.3.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон нийтийн эзэмшлийн зарим ТАХ-ний хадгалалт, хамгаалалтад хангалтгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалтын байдалтай танилцахад дараах зөрчил дутагдал илэрсэн. Үүнд:



Баян-өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хийгдсэн Уртбулаг багийн 5-4 дүгээр байранд жишиг орц байгуулах ажил чанаргүй хийгдсэн байна.



Баян-өндөр сумын ОНХС-ын хөрөнгөөр 2023 онд хийгдсэн Эрдэнэ багийн 5, 6-р гудамжны хүүхдийн тоглоомын талбай, Согоот баг 6-14, 17 дугаар байрнуудын гадна хүүхдийн тоглоомын талбай шинээр хийх ажлуудын эвдэрсэн байна.

³³ Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцаар хангах 30 айлын орон сууцны барилга – гэрээний дүн - 4,763.6 сая төгрөг, 2023 онд батлагдсан төсөв 2,250.0 сая төгрөг.

Баян-өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хийгдсэн Согоот багийн 6-12, 20 дугаар байрны орцны кодтой хаалга солих, Зэст багийн 1-4, 5 дугаар байрны орцны кодтой хаалга солих ажлуудын зарим хаалганы соронзон код эвдэрсэн, ажиллахгүй болсон байна.



Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хийгдсэн Боловсрол хөтөлбөрийн хүрээнд ЕБС-д Сандал ширээ худалдан авах ажлын хүрээнд нийлүүлсэн дунд ангийн ширээ сандал ашиглалтын явцад эвдэрч, гэмтсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын 9.12³⁴ дахь заалттай нийцэхгүй байна.

³⁴ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12-д “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.”

Бүлэг 3 ОНХС-ийн үйл ажиллагаанд тавьж буй хяналтын үр дүн хангалтгүйгээс зөрчил дутагдал арилахгүй байна.

3.1 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ТАХ-нд тодорхой түвшинд хяналт хэрэгжүүлж буй боловч гүйцэтгэлийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна.

3.1.1 Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад аймгийн СХДАА, сумын ИТХ-аас хяналт хэрэгжүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.4-т “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина” гэж заасан байна.

Аймгийн ИТХ-аас Баян-өндөр, Жаргалант сумын ИТХ-д нийтийн сонсголын тухай хуулийн хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад төсвийн хяналтын сонсгол хийх ажлыг зохион байгуулах тухай албан бичиг хүргүүлснээс өөр хяналт хэрэгжүүлээгүй байна.

Жаргалант сумын ИТХ-ын дарга болон Засаг дарга нарын томилсон ажлын хэсгүүд хамтран сумын ОНХС-ийн 2023 оны үйл ажиллагаанд 2 удаагийн хяналт хэрэгжүүлэн ажилласан байна. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс болон Орон нутгийн өмчийн газраас 2023 оны худалдан авах ажиллагаанд тус бүр хяналтыг хэрэгжүүлж, дүгнэлт зөвлөмжийг өгч ажилласан байна.

Жаргалант сумын ОНХС-ийн 2023 оны төсөв санхүү, үйл ажиллагаанд аймгийн СХДАА-аас дотоод аудит хийж, 5 зөвлөмж, удирдлагын мэдээллийн системийн мэдээлэл оруулалттай холбоотой 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

3.1.2 ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад Хот байгуулалт барилга захиалагчийн алба болон тухайн аймаг, сумын ЗДТГ-аас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж буй ч төлөвлөсөн хугацаанд бүх ажлын гүйцэтгэлийг бүрэн хангаж чадахгүй байна.

Аймаг, сумдын ОНХС-аар санхүүжүүлж худалдан авсан бараа, материал, засварын ажлуудыг аймаг, сумдын ЗДТГ-аас болон ашиглагч байгууллагаас оролцсон ажлын хэсэг хүлээн авч, нийлүүлэлтэд хяналт тавьж, гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байна.

Барилга, байгууламж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажлуудад аймгийн “Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ-с захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, ажил тус бүрээр хяналтын инженер томилогдон, тухай бүрд ил далд ажлын актаар баталгаажуулж, гүйцэтгэлийн төсвийг гаргаж, санхүүжилтийг олгосон байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлж буй ажлуудын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаас хяналт хэрэгжүүлж буй хэдий ч зарим ажлууд хугацаа хоцрох, он дамжин хэрэгжиж буй байдал тасралтгүй гарсаар байгаа нь захиалагчийн хяналт хангалттай хэрэгжиж чадахгүй байгааг илтгэж байна.

3.1.3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас аймаг, сумын ОНХС-ийн 2021 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийсэн байна. Мөн 2022, 2023 оны санхүүгийн тайланг түүвэрт хамруулан аудитыг гүйцэтгэсэн.

Хүснэгт 12. Аймаг сумын ОНХС-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шийдвэр, түүний хэрэгжилт /сая.төгрөг/

Д/д	Аймаг, сумын нэр	Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хэрэгжилтийн хувь
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Орхон аймгийн ОНХС	1	0.6	2	10.9	0	0.0	100%
2	Баян-Өндөр сумын ОНХС	2	0.5	0	0.0	1	181.5	100%
3	Жаргалант сумын ОНХС	0	0.0	0	0.0	2	96.4	100%
Нийт дүн		3	1.1	2	10.9	3	277.9	

3.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам, зааврын дагуу тайлагнаагүй байна.

3.2.1 Аймгийн ЗДТГ-ын ХБТХО-ын хэлтэс чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын 9.3-т “Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна” гэж заасан байна.

Аймгийн ЗДТГ-н ХБТХО-н хэлтэс нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ТАХ-ний тайлан, мэдээг сум бүрээр гаргуулан авч, дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар нэгдсэн тайлан бэлтгэж гаргаагүй байна.

Мөн журмын 9.9³⁵-д заасны дагуу аймаг, сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг нэгтгэж 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал

³⁵ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын “9.9-д “Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх ...”

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст хүргүүлээгүй байна.

3.2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хийгдсэн 28 ТАХ-г бүртгэл тайланд тусгасан байдлыг шалгахад “Миний гудамж, бидний гэр” төслийн хүрээнд хийгдсэн цэвэр, бохир усны төв шугамаас салбар шугам сүлжээ татах ажлуудыг “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК, замыг тусгаарлах тэмдэглэгээ, сайжруулсан шороон замын ажлуудыг Хот тохижуулах газар, гэрэлтүүлгийн ажлуудыг “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК данс бүртгэлдээ тус тус тусгаж, тайлагнасан байна.

Баян-Өндөр сумын ОНХС-ын хөрөнгөөр 2023 онд хийгдсэн 80 ТАХ-г бүртгэл тайланд тусгасан байдлыг шалгахад гэрэлтүүлгийн ажлуудыг “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК, камержуулалтын ажлыг Мэдээлэл шуурхай удирдлагын төв, явган хүний замын ажлууд болон тоглоомын талбайн ажлуудыг Хот тохижуулах газар, багуудын тохижилт, тоног төхөөрөмж, бусад ТАХ-г Баян-Өндөр сумын ЗДТГ данс бүртгэлдээ бүрэн тусгасан байна.

Жаргалант сумын ОНХС-ын хөрөнгөөр 2023 онд хийгдсэн 57 ТАХ-ний гудамж хоорондын гэрэлтүүлгийг сайжруулах ажлыг “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК, төсөвт байгууллагуудын засвар, тоног төхөөрөмжүүдийг тухайн байгууллагуудад, бусад ТАХ-г Жаргалант сумын ЗДТГ данс бүртгэлдээ тусгасан байна.

3.2.3 Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг удирдлагын мэдээллийн системд хэрэгжиж дуусаагүй ТАХ-г дутуу оруулсан байна.

Сангийн яамны удирдлагын системд 2023 оны ОНХС-аар Орхон аймагт хэрэгжүүлэхээр батлагдсан 37 ажлаас 28 ажлын мэдээллийг оруулсан, өмнөх оноос дамжин ирсэн 2 ажил, шинээр хийгдэх 7 ажил нийт 9 ажлын мэдээллийг оруулаагүй байна.

Дутуу оруулсан ажлууд нь 2023 онд огт хэрэгжээгүй болон дутуу хэрэгжсэн он дамжин хийгдэж буй ажлууд байна.

Аймгийн СХДАА-ны 2024 оны төлөвлөгөөний дагуу Жаргалант сумын ОНХС-ийн 2023 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, ОНХС-ийн 2023 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын мэдээллийг удирдлагын мэдээллийн системд зөрүүтэй оруулсан, хөтөлбөр төсөл арга хэмжээний ажлын явц, гүйцэтгэлийн хувь, тендер сонгон шалгаруулсан журам, ажил гүйцэтгэгч байгууллагын мэдээлэл зэргийг мэдээлээгүйд албан шаардлага өгснийг хэрэгжүүлж 2023 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтын мэдээллүүдийг аудит хийх явцад бүрэн оруулсан байна.

Харин Баян-Өндөр сумын хувьд ИТХ-аар батлагдсан 80 ажлаас 73 ажлын мэдээллийг бүрэн оруулсан, 7 ажлын үр дүн, өмчлөл талбарын мэдээллийг дутуу оруулсан байна. Хяналт хэсгийг аймаг болон 2 сум оруулаагүй байна.

3.2.4 ОНХС-н хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цаг тухай бүрд нь мэдээлсэн байна.

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1.15-д “орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 11 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар,” шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэхээр заажээ. Орхон аймаг ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг хугацаандаа, Жаргалант сумын хувьд ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) хагас жилийн санхүүгийн тайланг 1 мэдээллийг хугацаа хоцроож, Баян-Өндөр сум ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) 3 мэдээллийг хугацаа хоцроож, бусад мэдээллийг бүрэн оруулсан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг газрын тосны орлого тасарсантай холбоотойгоор 188.1 сая төгрөгөөр дутуу олгосон байна.
- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас Баян-Өндөр сумын орон нутгийн хөгжлийн санд 23.0 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон байна.
- Аймгийн ОНХС-д “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн хамтын ажиллагааны хүрээнд 2,800.0 сая төгрөг, сумдын ОНХС-д малын тоо толгойн албан татварын 60.3 сая төгрөгийг тус тус нэмж төлөвлөсөн байна.
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө сумдын саналын жагсаалтыг авч эрэмбэлээгүй байна.
- ОНХС-ийн төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа хангалтгүй, иргэдийн санал аваагүй зарим ТАХ-г төлөвлөж, ИТХ-аар баталсан байна.
- Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим ТАХ-г төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулаагүй байна.
- Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хууль, журмаар тогтоосон чиг үүрэгт хамаарах ТАХ-г хэрэгжүүлэхээр тусгасан байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийтийн эзэмшлийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй, цаг хугацаандаа хэрэгжүүлж дуусгахад анхаарах шаардлагатай байна.
- Сангийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн зарим заалтуудыг зөрчин зохион байгуулсан байна.
- Жаргалант сумын ОНХС-д болзошгүй аваарын зардал 209.0 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 204.8 сая төгрөг зарцуулсан байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг аймгийн хэмжээнд нэгтгэн судалж, тооцоогүй байна.
- Өмнөх онуудад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ТАХ-г хугацаанд нь ашиглалтад оруулаагүйгээс бодит үр дүн гарахгүй байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн томоохон төсөл арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахаар байна
- ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон зарим ТАХ нь хугацаандаа бүрэн ашиглалтад ороогүй, гэр хороололд тавигдсан шугам сүлжээнд холбогдох айл, өрхийн идэвх, оролцооноос хамаарч ОНХС-аар хэрэгжүүлсэн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.
- ОНХС-ийн үйл ажиллагаанд тавьж буй хяналтын үр дүн хангалтгүйгээс зөрчил дутагдал арилахгүй байна.
- Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтын ТАХ-нд тодорхой түвшинд хяналт хэрэгжүүлж буй боловч гүйцэтгэлийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна.
- ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад Хот байгуулалт барилга захиалагчийн алба болон аймаг, сумын ЗДТГ-аас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллаж буй ч төлөвлөсөн хугацаанд бүх ажлын гүйцэтгэлийг бүрэн хангаж чадахгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг санал тус бүрээр холбогдох журмын дагуу төлөвлөгдсөн эсэхийг хянах хэлэлцэн батлах, нийтэд мэдээлэх.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хяналт хэрэгжүүлэх.

Аймгийн Засаг даргад

1. ОНХС-н хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хууль, журмын дагуу боловсруулан бэлтгэж, тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах.
2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг төлөвлөсөн хугацаанд бүрэн гүйцэт хэрэгжүүлэхэд анхаарч, холбогдох шийдвэрүүдийг оновчтой гаргаж, зохион байгуулалтад хяналт тавьж ажиллах.
3. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг холбогдох хууль, аргачлал, журамд нийцүүлэн зохион байгуулах, хяналт тавих.

Сумдын Засаг дарга нарт

1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, аргачлал, журамд нийцүүлэн зохион байгуулах, хяналт тавих
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасан зориулалтын дагуу төлөвлөж, зарцуулах, хэрэгжилтийг төлөвлөсөн хугацаанд бүрэн хангах талаар хяналт тавьж ажиллах
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаар иргэдэд хүрэх мэдээллийг үр дүнтэй зохион байгуулах, иргэд, олон нийтийн оролцоо, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах

Аймгийн ЗДТГ-н ХБТХО-н хэлтэст

1. ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулж байх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

Тайланд тусгах саналгүй тул албан бичгүүдийг хавсаргав.


**ОРХОН АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: 7035 5590, Факс: (976)7035 2621
Цахим шуудан: info@erdenet.mn

2024.07.05 № 06/2023
танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө, гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА С.ДАВААДОРЖ


**ОРХОН АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА**
Нутгийн удирдлагын ордон, Жаргалант баг,
Жаргалант сум, Орхон аймаг, 61010, Утас: 7039-7203
Цахим хуудас: www.erdenet.mn

2024.07.05 № 01/443
танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө, гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцав.

ЗАСАГ ДАРГА Б.ЗОРИГТБАЯР

6124010216

D: Албан ёсоор А-5


**ОРХОН АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
Ш.Отгонбилэгийн гудамж, Оюут Баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61025
Утас: 70357965, факс: 70350965
Цахим хаяг: www.bayanundur.mn
Цахим шуудан: buzdtg@gmail.com

2024.07.05 № 03/1097
Танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөөнд хийсэн аудитын тайлантай танилцлаа.

ДАРГА Ш.ӨЛЗИЙБАЯР